



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар A/726

Арвайхээр

Бүх тендерээс татгалзаж, гэрээ шууд
байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 78 дүгээр зөвлөмжийн дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт суудлын автомашин нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах (ӨВАОНӨГ/201811060) тендерт шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул хүчингүй болгосугай.

2. Дээрх хүчингүй болсон тендерийг холбогдох хууль, журмын дагуу гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101606